

## **ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ШААРДЛАГА**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “ХЗХ” гэх)-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбоонд тавигдах шаардлагыг тогтоохтой холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.ХЗХ нь энэхүү журам болон холбогдох бусад хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг дагаж мөрдөнө.

### **ХОЁР. ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ШААРДЛАГА**

#### **2.1.ХЗХ үйл ажиллагаандаа дараах шаардлагыг мөрдөж ажиллана:**

2.1.1.Бүх гишүүдийн ээлжит хурлыг хуулийн хугацаанд зарлан хуралдуулж, хурлын тэмдэглэлийг хурал хуралдсанаас хойш 30 хоногийн дотор Хороонд цахимаар хүргүүлэх;

2.1.2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу харилцагч/гишүүнийг таньж мэдэх ажиллагааг гүйцэтгэж, эцсийн өмчлөгчийг тогтоох арга хэмжээ авах, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны <https://goaml.mongolbank.mn/> цахим системд бүртгүүлэн сэжигтэй гүйлгээг 24 цагийн дотор, 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүн бүхий бэлэн мөнгөний 1 гүйлгээний мэдээллийг ажлын 5 хоногийн дотор мэдээлэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулгыг хагас жил тутам Хороонд цахимаар мэдэгдэх;

2.1.3.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-т заасны дагуу хоршооны үйл ажиллагааны онцлогт нийцсэн “Дотоод хяналтын хөтөлбөр”-ийг боловсруулан бүх гишүүдийн хурлаар батлах, энэхүү хуулийн 14.4.11-т заасны дагуу дотоод хяналтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилон, тогтмол хяналт тавьж ажиллах;

2.1.4.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, журам, заавар, загвар, зөвлөмжийн дагуу холбогдох дотоод журам, заавар, аргачлалыг бүх гишүүдийн хурал болон тэргүүлэгчдийн зөвлөлөөр баталж мөрдөх;

2.1.5.Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;

2.1.6.Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал нь сонгогдож, томилогдсоноос хойш 6 сарын хугацаанд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх;

2.1.7.Тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч өөрчлөгдсөн бол энэхүү шаардлагын 2.1.5, Хадгаламж, зээлийн

хоршооны тухай хуульд заасан шаардлагыг хангасан болохыг нотлох баримтын хамт ажлын 10 өдрийн дотор Хороонд цахимаар мэдэгдэх;

2.1.8. Үйл ажиллагаа явуулах ажлын байр техник, тоног төхөөрөмж, санхүүгийн программ хангамж нь тухайн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, шаардлагыг хангасан байх;

2.1.9. Үйл ажиллагаа явуулах ажлын байр нь барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулсан байх;

2.1.10. Гишүүдийн оруулж буй хувь хөрөнгө тухайн иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны үйл ажиллагаанаас бий болсон орлого эсэхийг ХЗХ тухай бүр нягталдаг байх;

2.1.11. ХЗХ нь албан ёсны цахим шуудангийн хаяг /ХЗХ-ны нэрийг тусгасан/-тай байх, өөрчилсөн бол ажлын 5 өдрийн дотор Хороонд цахимаар мэдэгдэх;

2.1.12. ХЗХ нь оноосон нэр өөрчлөгдсөн тохиолдолд бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн шийдвэр, ХЗХ-ны дүрэмд тусгасан шинэчилсэн дүрэм болон бүх гишүүдэд оноосон нэрийн өөрчлөлтийн талаар мэдээлснийг нотлох баримтын хамт ажлын 5 өдрийн дотор Хороонд цахимаар мэдэгдэх.

## **2.2. Салбар байгуулахад тавигдах шаардлага:**

2.2.1. ХЗХ нь салбар байгуулсан тохиолдолд бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн шийдвэр, ХЗХ-ны дүрэмд тусгасан шинэчилсэн дүрэм болон бүх гишүүдэд салбарын талаар мэдээлснийг нотлох баримтын хамт ажлын 7 өдрийн дотор Хороонд цахимаар мэдэгдэх;

2.2.2. Салбар нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасан гишүүнчлэлийн нөхцөлийг хангасан байх;

2.2.3. Салбарын захирал нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6, Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлагыг хангасан байх;

2.2.4. Салбарын захирал нь сонгогдож, томилогдсоноос хойш 6 сарын хугацаанд Монголын хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх;

2.2.5. Салбарын ажлын байр, техник, тоног төхөөрөмж, санхүүгийн программ хангамж нь тухайн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл, шаардлагыг хангасан байх;

2.2.6. Салбарын ажлын байр нь барилга байгууламжийн гаднах орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор дүрс бичлэгийн техник, хэрэгсэл суурилуулсан байх.

## **2.3. Хадгаламжийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага:**

2.3.1. Хадгаламжийн үйл ажиллагаанд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 16 дугаар зүйл, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 2 дугаар бүлгийг мөрдлөг болгох;

2.3.2. Хадгаламжийн төрлийг тодорхойлохдоо гадаад, дотоод орчин, макро эдийн засгийн тэнцвэртэй байдал, санхүүгийн зах зээлийн эрсдэлийн түвшинг үнэлсэн судалгаанд суурилсан шийдвэр гаргах;

2.3.3. Хадгаламжийн хүүг тогтоохдоо үйл ажиллагааны орлого, зардал, өгөөж, эрсдэлийг тооцож, салбарын болон тухайн орон нутгийн зах зээлийн дундаж хүүг харгалзаж үзэх;

2.3.4. Хадгаламжийн бүтээгдэхүүн, хүү, шимтгэл хүлээх эрх, үүргийг гишүүдэд танилцуулах, хадгаламжийн бүтээгдэхүүний нөхцөлд орсон өөрчлөлтийг тухай бүр гишүүдэд мэдэгдэх;

2.3.5. Хадгаламжийн гэрээг бичгээр эсхүл цахимаар байгуулж болно;

2.3.6.Хадгаламжийн гэрээнд хадгалах хугацаа, хүүгийн хэмжээ, хадгаламжийн дүн, хүү тооцох аргачлал, гэрээг сунгах, цуцлах нөхцөл, талуудын хүлээх үүрэг хариуцлагыг тусгана.

#### **2.4.Зээлийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага:**

2.4.1.Зээлийн үйл ажиллагаанд Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 17 дугаар зүйл, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 4 дүгээр бүлгийг мөрдлөг болгох;

2.4.2.Зээлийн хүүг тогтоохдоо үйл ажиллагааны орлого, зардал, цэвэр орлогыг тооцож, салбарын болон тухайн орон нутгийн зах зээлийн дундаж хүүг харгалзаж үзэх;

2.4.3.Зээлийн хорооны шийдвэрийн дагуу зээлийн гэрээг бичгээр байгуулж болно;

2.4.4.ХЗХ болон зээлдэгч харилцан тохиролцсоны үндсэн дээр зээлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно;

2.4.5.Зээлийг гэрээний үндсэн дээр тодорхой зориулалт, хугацаа, эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хүүтэй болон хүүгүй олгож болно;

2.4.6.Зээлдэгчид зээл олгох болон зээлд өөрчлөлт орох бүр зээлийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд тогтмол нийлүүлнэ;

2.4.7.Зээлийн талаар баримтлах бодлого боловсруулж, тухайн үеийн байдал, хэтийн төлөвийг судалж, эрсдэлийг тооцож ажиллах.

#### **2.5.Финтек зээлийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага:**

2.5.1.Гишүүнтэй биечлэн байгуулсан гэрээний үндсэн дээр гишүүдэд зээл олгох үйлчилгээг дэвшилтэт технологийн шийдэл ашиглан цахим (цаашид “финтек” гэх)-аар эрхэлж болно;

2.5.2.Финтек зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд гаргахаас ажлын 15 өдрийн өмнө Хороонд урьдчилан танилцуулна;

2.5.3.ISO/IEC 27001 стандартыг хангасан байна;

2.5.4.Финтек зээлийн үйлчилгээ үзүүлэхдээ зээлийн хорооноос гаргасан шийдвэрийг үндэслэн зээлийн шугам хэлбэрээр зээл олгох эрхийг нээж мэдээллийг энэхүү журмын 2.4.6-д заасны дагуу Зээлийн мэдээллийн санд мэдээлнэ;

2.5.5.ХЗХ нь үйл ажиллагааны зардлаа бууруулах зорилгоор гуравдагч этгээдийн мэдээллийн технологийн системд холбогдон тухайн программ хангамжид боловсруулсан мэдээллийг ашиглан зээл олгох тохиолдолд энэ журмын 2.5.2-т заасны дагуу Хороонд урьдчилан мэдэгдэнэ. Гуравдагч этгээд нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан шаардлагыг хангасан байна;

2.5.6. ХЗХ нь финтек зээлийн бүтээгдэхүүн гаргасантай холбоотойгоор Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, 17.1.7-д заасан үүргийг биелүүлж ажиллах ба холбогдох мэдээллийг дараа оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

### **ГУРАВ. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН ҮНДЭСНИЙ ХОЛБООНД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

3.1.Үндэсний холбоо дараах шаардлагыг хангана:

3.1.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт хадгаламж, зээлийн хоршоодын 51-ээс доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх;

3.1.2.Хоршооны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д заасан Хоршооллын нэгдсэн холбоонд гишүүнээр элссэн байх;

3.1.3.Адил төрлийн үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагатай хамтран ажилладаг эсхүл гишүүнчлэлтэй байх;

3.1.4.Хадгаламж, зээлийн хоршооны салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөг баталсан байх;

3.1.5.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т заасан шаардлагыг дүрэмдээ тусгасан байх.

3.2.Хороо Үндэсний холбоотой санамж бичиг байгуулан, жил бүр биелэлтийг дүгнэж, хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллана.